



АРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

**САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ**

Хашаат сумын ИТХ-ын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн аудитын тайлан

**Аудитын код: АРА-2022/108/-НА-СТА-ТШЗ**

<p>Цахим хуудас: <a href="http://www.audit.mn">www.audit.mn</a> Архангай аймаг 2022 он</p>	<p>Дарга, Тэргүүлэх аудитор Т.Байгалмаа Утас: 7033-3141 Цахим хаяг: Baigalmaat@audit.gov.mn</p> <p>Аудитын менежер Д.Нэргүйбаатар Утас: 7033-2860 Цахим хаяг: Nerguibaatard@audit.gov.mn</p> <p>Аудитор П.Цэцэгдулам Цахим хаяг: Tsetsegdulamp@audit.gov.mn</p>
--	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## Агуулга

1.Аудитын санал, дүгнэлт	
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл .....	2
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан .....	4
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан .....	4
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан .....	6
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	7
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан .....	9
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	9
3. Аудитын тайлан .....	9
3.1 Ерөнхий зүйл .....	11
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт .....	11
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....	12
3.4 Материаллаг байдал.....	12
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга .....	12
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв .....	13
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг.....	14
3.8 Аудитын гол асуудал.....	14
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал .....	15
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт .....	15
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	16
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал .....	16
4. Аудитын илрүүлэлт.....	16
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл .....	17

## Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ЗГ	Засгийн газар



**АРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

65130 Цэцэрлэг, Архангай аймаг  
Утас/Факс: 976-70333141  
И-мэйл: arkhangai@audit.gov.mn

2022.02.24 № 68  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

Аудитын санал дүгнэлт

ХАШААТ СУМЫН ИРГЭДИЙН  
ТӨЛӨӨЛӨГЧИЙН ХУРЛЫН НАРИЙН  
БИЧГИЙН ДАРГА Б.ХАТАНБААТАР  
ТАНАА

**Зөрчилгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хашаат сумын ИТХ-ын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Хашаат сумын ИТХ-ын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Т.БАЙГАЛМАА



## 2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2021.12.31-ны өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>499,800.00</b>	<b>880,300.00</b>
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	<b>499,800.00</b>	<b>880,300.00</b>
<b>35400</b>	<b>Хангамжийн материал</b>	<b>499,800.00</b>	<b>880,300.00</b>
35410	Бичиг хэргийн материал	371,800.00	352,300.00
35420	Аж ахуйн материал	128,000.00	528,000.00
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>12,090,066.51</b>	<b>11,001,283.26</b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	<b>12,090,066.51</b>	<b>11,001,283.26</b>
39100	Газар	0.00	0.00
<b>39200</b>	<b>Биет хөрөнгө</b>	<b>12,090,066.51</b>	<b>11,001,283.26</b>
39203	Авто-тээврийн хэрэгсэл	0.00	26,000,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	0.00	-25,583,333.28
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	12,532,040.00	13,532,040.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	-2,444,640.00	-4,306,589.97
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	7,522,784.70	7,522,784.70
39208	Хуримтлагдсан элэгдэл	-5,520,118.19	-6,163,618.19
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b>12,589,866.51</b>	<b>11,881,583.26</b>
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>12,589,866.51</b>	<b>11,881,583.26</b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	<b>12,589,866.51</b>	<b>11,881,583.26</b>
51100	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	2,942,300.00	2,942,300.00
<b>51200</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	<b>9,158,646.91</b>	<b>8,450,363.66</b>
51210	Өмнөх үеийн үр дүн	9,158,646.91	9,158,646.91
51220	Тайлант үеийн үр дүн		-708,283.25
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	488,919.60	488,919.60
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>12,589,866.51</b>	<b>11,881,583.26</b>

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2021.12.31-ны өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	90,177,500.00	108,471,466.73
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	0.00	5,416,666.73
120	Нийтлэг татварын бус орлого	0.00	5,416,666.73
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	0.00	5,416,666.73
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	0.00	5,416,666.73
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	90,177,500.00	103,054,800.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	0.00	420,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	90,177,500.00	102,634,800.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	90,177,500.00	102,634,800.00
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	79,616,099.84	109,179,749.98
21	УРСГАЛ ЗАРДАЛ	79,616,099.84	109,179,749.98
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	71,842,436.84	74,391,753.98
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	43,106,388.00	42,444,437.00
210101	Үндсэн цалин	43,106,388.00	42,444,437.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	5,388,282.00	5,500,467.00
210201	Тэтгэврийн даатгал	3,664,034.68	3,818,970.34
210202	Тэтгэмжийн даатгал	431,063.08	424,444.37
210203	ҮОМШӨ-ний даатгал	344,847.27	339,555.59
210204	Ажилгүйдлийн даатгал	86,210.81	83,080.68
210205	Эрүүл мэндийн даатгал	862,126.16	834,416.02
2104	Хангамж, бараа материалын зардал	2,855,840.00	2,894,310.00
210401	Бичиг хэрэг	551,100.00	526,600.00
210402	Тээвэр, шатахуун	2,029,740.00	2,097,710.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	275,000.00	270,000.00
2107	Томилолт, зочны зардал	123,000.00	206,000.00
210701	Гадаад албан томилолт	0.00	0.00
210702	Дотоод албан томилолт	123,000.00	206,000.00
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	0.00	0.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	19,547,327.00	15,411,090.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	19,247,327.00	15,011,090.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	300,000.00	400,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	821,599.84	7,935,449.98
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	0.00	10,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	0.00	420,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	821,599.84	7,505,449.98
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	7,773,663.00	34,787,996.00
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	0.00	0.00
213101	Засгийн газрын дотоод шилжүүлэг	0.00	0.00
213102	Засгийн газрын гадаад шилжүүлэг	0.00	0.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	1,453,000.00	1,300,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,453,000.00	1,300,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	6,320,663.00	33,487,996.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	6,320,663.00	33,487,996.00
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	10,561,400.16	-708,283.25
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	10,561,400.16	-708,283.25

### 2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2021.12.31-ны өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
10	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	2,942,300.00	488,919.60	9,158,646.91	12,589,866.51
11	2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	2,942,300.00	488,919.60	9,158,646.91	12,589,866.51
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	2,942,300.00	488,919.60	9,158,646.91	12,589,866.51
19	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	-708,283.25	-708,283.25
20	2021 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	2,942,300.00	488,919.60	8,450,363.66	11,881,583.26

## 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2021.12.31-ны өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	90,177,500.00	103,054,800.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	90,177,500.00	103,054,800.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	0.00	420,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	90,177,500.00	102,634,800.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	90,177,500.00	102,634,800.00
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	78,977,500.00	102,054,800.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	78,977,500.00	102,054,800.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	71,203,837.00	66,866,804.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	43,106,388.00	42,444,437.00
210101	Үндсэн цалин	43,106,388.00	42,444,437.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	5,388,282.00	5,500,467.00
210201	Тэтгэврийн даатгал	3,664,040.00	3,818,970.34
210202	Тэтгэмжийн даатгал	431,062.00	424,444.37
210203	ҮОМШӨ-ний даатгал	344,846.00	339,555.80
210204	Ажилгүйдлийн даатгал	86,209.00	83,080.47
210205	Эрүүл мэндийн даатгал	862,125.00	834,416.02
2104	Хангамж, бараа материалын зардал	3,038,840.00	2,864,810.00
210401	Бичиг хэрэг	619,100.00	497,100.00
210402	Тээвэр, шатахуун	2,029,740.00	2,097,710.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	275,000.00	270,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	115,000.00	0.00
2107	Томилолт, зочны зардал	123,000.00	206,000.00
210701	Гадаад албан томилолт	0.00	0.00
210702	Дотоод албан томилолт	123,000.00	206,000.00
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	0.00	0.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	19,547,327.00	15,431,090.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	19,247,327.00	15,031,090.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	300,000.00	400,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	0.00	420,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	0.00	420,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	7,773,663.00	35,187,996.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	1,453,000.00	1,700,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,453,000.00	1,700,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	6,320,663.00	33,487,996.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	6,320,663.00	33,487,996.00
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	11,200,000.00	1,000,000.00
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	11,200,000.00	1,000,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	11,200,000.00	1,000,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	11,200,000.00	1,000,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	11,200,000.00	1,000,000.00

VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	-11,200,000.00	-1,000,000.00
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	0.00	0.00
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.00	0.00
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.00	0.00

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2021.12.31-ны өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	102,634,800.00	69,146,804.00	33,487,996.00	67.37
21	УРСГАЛ ЗАРДАЛ	102,634,800.00	69,146,804.00	33,487,996.00	67.37
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	100,634,800.00	67,446,804.00	33,187,996.00	67.02
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	43,664,700.00	42,444,437.00	1,220,263.00	97.21
210101	Үндсэн цалин	43,664,700.00	42,444,437.00	1,220,263.00	97.21
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	5,894,700.00	5,500,467.00	394,233.00	93.31
210201	Тэтгэврийн даатгал	4,148,100.00	3,818,970.34	329,129.66	92.07
210202	Тэтгэмжийн даатгал	436,700.00	424,444.37	12,255.63	97.19
210203	ҮОМШӨ-ний даатгал	349,300.00	339,555.80	9,744.20	97.21
210204	Ажилгүйдлийн даатгал	87,300.00	83,080.47	4,219.53	95.17
210205	Эрүүл мэндийн даатгал	873,300.00	834,416.02	38,883.98	95.55
2104	Хангамж, бараа материалын зардал	3,125,400.00	2,864,810.00	260,590.00	91.66
210401	Бичиг хэрэг	575,400.00	497,100.00	78,300.00	86.39
210402	Тээвэр, шатахуун	2,100,000.00	2,097,710.00	2,290.00	99.89
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	300,000.00	270,000.00	30,000.00	90.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	150,000.00	0.00	150,000.00	0.00
2107	Томилолт, зочны зардал	500,000.00	206,000.00	294,000.00	41.20
210702	Дотоод албан томилолт	500,000.00	206,000.00	294,000.00	41.20
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	38,450,000.00	16,431,090.00	22,018,910.00	42.73
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	38,000,000.00	16,031,090.00	21,968,910.00	42.19
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	450,000.00	400,000.00	50,000.00	88.89
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	9,000,000.00	0.00	9,000,000.00	0.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	9,000,000.00	0.00	9,000,000.00	0.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	2,000,000.00	1,700,000.00	300,000.00	85.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	2,000,000.00	1,700,000.00	300,000.00	85.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,000,000.00	1,700,000.00	300,000.00	85.00
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	102,634,800.00	69,146,804.00	33,487,996.00	67.37
32	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	102,634,800.00	69,146,804.00	33,487,996.00	67.37
320001	Орон нутгийн төсвөөс	102,634,800.00	69,146,804.00	33,487,996.00	67.37
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1	1	0.00	100.00
610001	Төсвийн байгууллага	1	1	0.00	100.00
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	2	2	0.00	100.00
620001	Удирдах ажилтан	1	1	0.00	100.00

620002	Гүйцэтгэх ажилтан	1	1	0.00	100.00
650011	Улс төрийн албан хаагч (УТ)	1	1	0.00	100.00

## 2.6 Нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

2021.12.31-ны өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	420,000.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	420,000.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	420,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	420,000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	420,000.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	420,000.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	420,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	420,000.00
IV	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)	
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-

### 3. Аудитын тайлан

#### 3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Архангай аймгийн Хашаат сумын ИТХ-ын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр тасалбар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Архангай аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор П.Цэцэгдулам гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Д.Нэргүйбаатар, дарга, тэргүүлэх аудитор Т.Байгалмаа нар тус тус хэрэгжүүлсэн.

Хашаат сумын ИТХ-ын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Архангай аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 17-ны өдрийн 02 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

#### 3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Хашаат сумын ИТХ нь нутгийн өөрөө удирдах байгууллагын шийдвэр, Улсын Их Хурлаас гаргасан хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэр, түүнтэй нийцүүлэн гаргасан нутгийн захиргааны шийдвэрүүдэд хяналт тавьж биелэлтийг хангуулах чиг үүрэг бүхий аймгийн ТЕЗ-ийн харьяа орон нутгийн төсвийн байгууллага байна.

Тус байгууллага нь тайлант онд *“Нутгийн өөрийн удирдлагыг бэхжүүлэх, төр засгийн бодлого шийдвэр, хууль тогтоомийг иргэд, хөдөлмөрчдөд байнга хүргэн мэдээлж, сурталчилгааг тогтмол хийх, бүх шатанд хариуцлага, сахилгыг өндөржүүлсний үндсэн дээр нийгэм эдийн засгийн тулгамдсан асуудлыг шийдвэрлэж, хуулийн дагуу зохицуулан түүний хэрэгжилтэд хяналт тавин ажиллах”* зорилт тавин ажилласан байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрдөх хууль, тогтоомж, бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- “Нийгмийн даатгалын сангийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хууль”-иар нийгмийн даатгалын шимтгэлийн хувь хэмжээ өөрчлөгдсөн
- ЗГ-ын 2021 оны 43 дугаар тогтоол “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай”
- ЗГ-ын 2021 оны 124 дүгээр тогтоол “Босго үнэ шинэчлэн батлах тухай”;
- Сангийн сайдын 2021 оны 190 дугаар тушаалаар “Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар”

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын

сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудиторроос шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### 3.3 САНХҮҮГИЙН ТАЙЛАГНАЛЫН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Тус байгууллагын 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккурель сууриар хөтөлсөн, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц гэж санхүүгийн тайлагналын үзэл баримтлалыг үнэлсэн.

### 3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2021 оны батлагдсан төсвийг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдлийг дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны батлагдсан төсөв 102.6 сая төгрөгөөс 1 хувиар буюу 1.0 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 хувь буюу 0.7 сая төгрөгөөр тогтоосон.

Гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг төлөвлөлтийн шатны ерөнхий материаллаг байдлыг хянаж үзээд шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзлээ.

### 3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Тус байгууллагын 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаар нийт хөрөнгийн дүн эхний үлдэгдлээс 0.7 сая төгрөгөөр буюу 5.6 хувиар буурсан материаллаг өөрчлөлт гарсан нь үндсэн хөрөнгийн данс байна.

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт	хувь
Бараа материал	0.5	0.8	0.3	60.0
Авлага	-	-	-	
Үндсэн хөрөнгө	12.0	11.0	(1.0)	(8.3)
<b>Нийт хөрөнгө</b>	<b>12.5</b>	<b>11.8</b>	<b>(0.7)</b>	<b>(5.6)</b>
Өр төлбөр	-	0	-	
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	12.5	11.8	(0.7)	(5.6)
<b>Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн</b>	<b>12.5</b>	<b>11.8</b>	<b>(0.7)</b>	<b>(5.6)</b>

Дансны үлдэгдэлд гарсан материаллаг дүнтэй дараах өөрчлөлтүүд байна. Үүнд:

- Бараа материал эхний үлдэгдлээс 60.0 хувиар өссөн байна.

Бараа материалын данс нь 0.5 сая төгрөгийн эхний үлдэгдэлтэй ба тайлант онд төсвийн хөрөнгөөр худалдан авсан 11.9 сая төгрөгөөр нэмэгдэж, тайлант онд 11.6 сая төгрөгийн бараа материалыг зарцуулан оны эцэст 0.8 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.

- Үндсэн хөрөнгө эхний үлдэгдлээс 8.3 хувиар буурсан байна.

Үндсэн хөрөнгө данс нь 12.0 сая төгрөгийн эхний үлдэгдэлтэй ба тайлант онд 1.0 сая төгрөгийн хөрөнгийг төсвийн хөрөнгөөр худалдаж авсан, шилжүүлэн авсан 26.0 сая төгрөг нийт 27.0 сая төгрөгөөр нэмэгдэж, тайлант хугацаанд байгуулсан 7.5 сая төгрөг, бусад 20.5 сая төгрөгийн элэгдэлийн зардлаар тус тус буурч 11.0 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.

- Цэвэр хөрөнгө өмчийн дүн өссөн нь тайлант хугацааны үр дүнтэй шууд холбоотой бөгөөд тайлант хугацаанд 0.7 сая төгрөгийн үр дүнг хүлээн зөвшөөрсөн байна.

## Хүснэгт 2. Санхүүгийн үр дүнгийн тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	/сая төгрөгөөр/		
	Өмнөх он	Тайлант он	Өөрчлөлт
Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	-	5.4	5.4
Нэмэлт санхүүжилт	-	0.4	0.4
Орон нутгийн төсвөөс	90.2	102.6	12.4
Эрүүл мэндийн даатгалын сангаас			-
<b>Үйл ажиллагааны орлого</b>	<b>90.2</b>	<b>108.4</b>	<b>18.2</b>
Цалин, шимтгэлийн зардал	48.5	47.9	(0.6)
Бараа ажил үйлчилгээний зардал	10.8	38.0	-
Бусдаар гүйцэтгүүлсэн нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	19.5	15.4	(4.1)
Бараа үйлчилгээний бусад зардал	0.8	7.9	7.1
Урсгал шилжүүлэг			-
Хөрөнгийн зардал			-
<b>Үйл ажиллагааны зардал</b>	<b>79.6</b>	<b>109.2</b>	<b>2.4</b>
<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)</b>	<b>10.5</b>	<b>(0.7)</b>	<b>(11.2)</b>

Хашаат сумын ИТХ-ын санхүүгийн үр дүнгийн тайлангийн үйл ажиллагааны орлого өмнөх оноос 18.3 сая төгрөгөөр өссөн нь тайлант онд үнэ төлбөргүй хүлээн авсан орлоготой холбоотой байна.

### 3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр, нийт зарлагыг 98.5 сая төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсөв захирагчийн хүргүүлсэн төсвийн төслийг нийт 4.1 сая төгрөгөөр нэмэгдүүлж нийт зардлыг 102.6 сая төгрөгөөр хянаж баталсан нь хүү торгуулийн орлоготой холбоотой байна.

### **3.6.2 Төсвийн гүйцэтгэл**

Тайлант онд батлагдсан төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 3 арга хэмжээнд орон нутгийн төсвөөс 102.6 сая төгрөгөөр санхүүжилт авч, урсгал үйл ажиллагаанд 69.1 сая төгрөг зарцуулан 33.5 сая төгрөгийг төсөвт буцаан төвлөрүүлж, тайлант онд батлагдсан төсвийг 32.6 хувиар хэмнэж төсвийн хэмнэлтийг бий болгосон байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### **3.6.3 Нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй. Тайлант онд нэмэлт санхүүжилтын дансаар дээд шатны төсөв захирагчаас төлөөлөгч нарыг чадавхижуулах сургалтад 0.4 сая төгрөг ирж бүрэн зарцуулсан байна.

### **3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг**

Хашаат сумын ИТХ нь тайлант онд сумын Эрүүл мэндийн төвөөс 26.0 сая төгрөгийн анхны өртөг бүхий УАЗ-фургон авто машиныг аймгийн ИТХ-ын 2021.04.16-ны өдрийн 13 дугаар тогтоолын дагуу шилжүүлсэн авч тайлан балансад бүртгэсэн байна.

### **3.8 Аудитын гол асуудал**

Тус байгууллага нь 2021 оны жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан стратегийн зорилтуудыг хангахад чиглэсэн 5 үндсэн зорилтын хүрээнд 42арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс дэвшүүлсэн зорилт, төлөвлөсөн арга хэмжээний хэрэгжилт 70 хувьтай байна.

Аудитын явцад санхүүгийн тайлангийн аудитад баримтлах ерөнхий чиглэлийн дагуу дараах судалгааг авч үнэлэхэд Үүнд:

- Төсвийн хэмнэлтийн талаар авсан арга хэмжээ, түүний үр дүн судалгааг авч үзэхэд нэг удаагийн тэтгэмж шагнал, урамшуулалын зардлаас бэлэг, дурсгалын зүйл худалдан авахад 1100.0 мянган төгрөг, төлөөлөгч нарыг чадвахижуулах сургалтын зардалд 420.0 мянган төгрөг нийт 1520.0 мянган төгрөгийг зарцуулсан нь Монгол Улсын Засгийн газрын “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай” 43-р тогтоолын 1.3, 1.5 дахь заалтуудтай нийцэхгүй байна.

- Тус байгууллага нь тайлант онд сумын Эрүүл мэндийн төвөөс шилжүүлэн авсан 26.0 сая төгрөгийн анхны өртөг бүхий УАЗ-фургон авто машиныг шилжүүлэн авч шатахууны зардалд 2.1 сая төгрөг, сэлбэг хэрэгсэлд 4.8 сая төгрөгийг тус тус зарцуулсан байна.

Харин бусад судалгаанд хамаарах мэдээлэлгүй байна.

### **3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

Санхүүгийн тайлангийн аудитаар Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг шалгаж үр дүнг баримтжуулсан /Local.audit.mn сайтад шивсэн/, Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай ЗГ-ын 43-р тогтоолын хэрэгжилтийг судалгаагаар шалгаж баримтжууллаа.

#### **3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т хамаарах төсөвт байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газар нь 6 дугаар зүйлийн 6.1, 6.4-т тус тус тусгасан мэдээллийг хуульд заасан хугацаанд ил тод мэдээлэх зохицуулалттай.

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаcт ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Хашаат сумын ИТХ нь тайлант хугацаанд оруулбал зохих 139 мэдээллийг хугацаанд нь мэдээлж, хөрөнгө мөнгө зарцуулсан 23 тушаал, шийдвэрийг бүрэн байршуулсан байна.

#### **3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд**

Тайланд онд Монгол Улсын Засгийн газрын “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай” 43 дугаар тогтоолыг мөрдөж ажиллахыг бүх шатны төсөв захирагчид даалгасан.Төсвийн хэмнэлтийг тогтоолын 1.1-д заасан үндсэн үйл ажиллагаатай холбоотой, зайлшгүй шаардлагатайгаас бусад бүх төрлийн зардал, арга хэмжээг тэвчиж, зардал гаргахгүй байх, батлагдсан төсөвт зардлын дүнд 10-аас доошгүй хувийн хэмнэлт гарахаар тооцож, урсгал болон хөрөнгийн зардлыг төлөвлөн хуваарилах гэсэн заалттай нийцүүлж үзэхэд 33.5 сая төгрөгийн хэмнэлтийг бий болгосон байна.

Тайлант онд нэг удаагийн тэтгэмж шагнал, урамшуулалын зардлаас бэлэг, дурсгалын зүйл худалдан авахад 1.1 сая төгрөг, төлөөлөгч нарыг чадвахижуулах сургалтын зардалд 0.4 сая төгрөг нийт 1.5 сая төгрөгийг зарцуулсан нь Монгол Улсын Засгийн газрын “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай” 43-р тогтоолын 1.3, 1.5 дахь заалтуудыг зөрчиж байна.

Шийдвэрлэсэн: Монгол Улсын Засгийн газрын “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай” 43-р тогтоолын хэрэгжилтийг хангаж ажиллах албан шаардлага хүргүүлэв.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцэж, бусад хууль тогтоомжийн хүрээнд Монгол Улсын Засгийн газрын “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай” 43-р тогтоолын хэрэгжилтыг холбогдох шалгууртай нийцэхгүй байна гэж дүгнэлээ.

### **3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт**

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар дотоод хяналттай холбоотой 1 заалт зөвлөмж хүргүүлж биелэлтийг хангуулсан.

### **3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал**

Дараагийн аудитаар авч үзэх асуудал гараагүй.

## **4. Аудитын илрүүлэлт**

Аудитаар илэрсэн 4.7 сая төгрөгийн алдаа зөрчилд зөвлөмж хүргүүлээ.

### **4.1 Зөвлөмж**

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Үндсэн хөрөнгийн данстай холбоотой асуудал

Илрүүлэлт: Үндсэн хөрөнгийн дэлгэрэнгүй бүртгэлээс үзэхэд 17 нэр төрлийн 4.7 сая төгрөгийн хөрөнгө элэгдлээрээ анхны өртөгөө бүрэн нөхсөн, ашиглалтын хугацаа дууссан байна.

Өгсөн зөвлөмж: Иймд Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31.3.2 “илүүдэл эд хөрөнгө болон элэгдэл хорогдлын шимтгэлээр анхны үнийг нь нөхсөн, түүнчлэн нөхөөгүй боловч гэмтэж, засаж сэлбээд өөр зориулалтаар ашиглаж болох эд хөрөнгийн үнийг төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагатай зөвшилцөн тогтоох” гэж заасны дагуу арга хэмжээ авч ажиллах.

-----oO-----

## 5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

Д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Санхүүгийн тайлангийн аудитын асуудал											
	Хашаат сумын ИТХ	1	4.7	0	0	0	0	0	0	1	4.7
	дүн	1	4.7	0	0	0	0	0	0	1	4.7
Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал											
	Хашаат сумын ИТХ	1	1.5	0	0	0	0	1	1.5	0	0
	дүн										
	<b>Нийт дүн</b>	<b>1</b>	<b>1.5</b>	<b>0</b>	<b>0</b>	<b>0</b>	<b>0</b>	<b>1</b>	<b>1.5</b>	<b>0</b>	<b>0</b>